



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗАР-Т

## АРДЧИЛСАН НАМ

Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Чингисийн өргөн чөлөө,  
Шинэ дэвшилт холбооны байр.

И-мэйл: info@demparty.mn, Вэбсайт: www.demparty.mn

2020.12.24 № 02/453  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Шаардлага хүргүүлэх тухай

Ардчилсан нам нь Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх Монгол Улсын үндэсний хэмжээний нам юм.

2017 оны 11 дүгээр сарын 29-өөс 2020 оны 07 дугаар сарын 24- нийг хүртэлх хугацаанд "Ардчилсан нам"-ийн даргаар ажиллаж байсан иргэн С.Эрдэнэ нь танай байгууллагад хандаж "Ардчилсан нам"-ийн бэлгэдэл, албан банк ашиглан намын дарга нэрээр "Ардчилсан нам"-ийн 1117237845 хяналтын дугаар бүхий тамга (тэмдэг)- гийг хүчингүй болгуулахаар хууль бус хүсэлт гаргасныг Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваанд ирүүлсэн танай байгууллагын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 8/10459 албан тоотоос олж мэдлээ.

Улс төрийн намын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт "Намын дотоод зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог намын дүрмээр зохицуулна." хэмээн заасан ба эдүгээ хүчин төгөлдөр мөрдөгдөж буй "Ардчилсан нам"-ийн үндсэн дүрмийн 3.10.1 дэх хэсэгт "Ардчилсан нам нь УИХ-ийн сонгуульд хамгийн олон суудал аваагүй тохиолдолд:", 3.10.1.1-т "Намын Дарга ... огцорсонд тооцно.", 5.17.6 дахь хэсэгт "Намын Даргыг ... ҮБХ-ний хурлаар чөлөөлж ... намын дараагийн Дарга сонгогдох хүртэл Намын Даргын эрх, үүрэг аль нэг дэд даргад шилжинэ" заасны дагуу иргэн С.Эрдэнэ нь намын даргаас чөлөөлөгдөж, Ардчилсан намын төлөөллийн төв байгууллага болох Үндэсний Бодлогын Хорооны хурлын 2020 оны 07 дугаар сарын 24-ний өр16/06 тоот тогтоолоор намын даргын түр орлон гүйцэтгэгчээр Ц.Туваан томилогдсоныг 2020 оны 11 дүгээр сарын 05-нд Улсын Дээд Шүүхэд хүсэлт гаргаж бүртгүүлсэн болно. Улс төрийн намын бүртгэлийг хариуцах эрх хэмжээнийхээ хувьд УДШ-ийн энэхүү шийдвэр нь Ардчилсан намыг хэн төлөөлөх вэ гэдгийг албажуулсан эцсийн шийдвэр бөгөөд шаардлагад хавсаргасан УДШ-ийн тамгын газрын 2020.12.22-ны өдрийн 5/5051 дугаарт албан бичгээр Ц.Туваан нь АН-ыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтнаар бүртгэгдсэн болох нь нотлогдоно.

Ардчилсан нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхлын хүрээнд улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс Монгол Улсын иргэд сайн дураараа эвлэлдэн нэгдсэн Улс төрийн олон нийтийн өмчийн этгээд бөгөөд Монгол Улсын иргэний хуулийн 64, "Ардчилсан нам"-ийн үндсэн дүрмийн 3.10.1, 5.17.6- дахь зүйл заалтуудын дагуу иргэн С.Эрдэнэ нь "Ардчилсан нам"-ийн бэлгэдэл, албан бланкыг ашиглах, төлөөлөх эрхгүй этгээд ба түүний энэ үйлдэл нь эрүүгийн хуулийн 22.12-д заасан гэмт хэргийн шинжтэй байна.

0000000

Улс төрийн намын тухай хуулиар аливаа намын зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, үүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулсан ба мөн хуульд заасанчлан намыг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэхээс татгалзах, намын бүртгэлд өөрчлөлт оруулах зэрэг эрх нь Улсын дээд шүүхэд олгогдсон байтал танай байгууллага холбогдох хууль тогтоомж, дүрэм журмаар төлөөлөх эрхгүй хууль бусаар намын блак ашигласан этгээдийн баримт бичгийг хүлээн авч хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулж байгаад харамсаж байна.

Бодит байдал, үйл баримт тодорхой байсаар атал танай байгууллагын хууль зөрчсөн үйл ажиллагаа хэт нэг талыг барьсан, эрх баригч Ардын намд үйлчилж байна хэмээн үзэж байгаа тул хууль бус шийдвэр зориудаар гаргавал хууль зөрчсөн албан тушаалтнуудад эрүүгийн хууль болон бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэх талаар зохих байгууллагуудад хандаж, үүнийгээ шударгаар шийдвэрлүүлэхээр улс төрийн тэмцэл хийх болохыг мэдэгдэж байна.

Иймд хууль зөрчсөн үйл ажиллагаагаа яаралтай таслан зогсоож, хуулиар оногдсон үүргээ биелүүлж, нэр барьж, хуурамч блак ашигласан С.Эрдэнэ гэх этгээдийн хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй болохоо мэдэгдэж, холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэхийг шаардаж байна.

Хавсралтаар,

1. "Ардчилсан нам"-ийн Үндэсний Бодлогын Хорооны хурлын 2020 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 16/06 тоот тогтоолын хуулбар

2. Улсын Дээд Шүүхийн Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 22- ний өдрийн 5/5051 албан тоотын хуулбар,

ХЭРЭГ ЭРХЛЭХ  
ГАЗРЫН ДАРГА



П.НҮРЗЭД